



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**




# **ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2015**



**Улаанбаатар хот  
2016 он**


Чингэлтэй дүүрэгт 2013-2015 онд нийт 132.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгджээ. Салбарын бүтцээр нь ангилвал 65.6 тэрбум төгрөг буюу 49.6 хувь нь дэд бүтэц тохижилтын ажил, 39.9 тэрбум төгрөг буюу 30.1 хувь нь боловсролын чиглэлд, 17.8 тэрбум төгрөг буюу 13.4 хувь нь нийгмийн чиглэлд, 6.0 тэрбум төгрөг буюу 4.5 хувь нь эрүүл мэндийн чиглэлд, 3.0 тэрбум төгрөг буюу 2.3 хувь нь төрийн захиргааны чиглэлд тус тус зарцуулагдсан байна.

Зураг 1. Санхүүжилтийн эх үүсвэр/ 2013-2015 он/



2015 онд 61.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж өмнөх оноос 24.7 тэрбум төгрөг буюу 66.7 хувиар өссөн байна. 2015 оны хөрөнгө оруулалтыг салбараар нь ангилвал 25.7 тэрбум төгрөг буюу 41.6 хувь нь дэд бүтцийн чиглэлээр, 6.2 тэрбум төгрөг буюу 10.0 хувь нь хот тохижилт, хот нийтийн аж ахуйг сайжруулах чиглэлээр, 3.5 тэрбум буюу 5.6 хувь нь эрүүл мэндийн салбарт, 24.3 тэрбум буюу 39.3 хувь нь боловсролын салбарт, 2.1 тэрбум буюу 3.4 хувь нь нийгмийн салбарт тус тус зарцуулагдсан байна.

Зураг 2. Санхүүжилтийн эх үүсвэр/2015 он/



2015 онд дүүргийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 2368.1 сая төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оноос 16.3 хувиар буюу 462.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.


Хүснэгт 1. ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажил

№	Хийсэн ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Ажлын тоо		Зарцуулсан дүн (сая.төг)	
			2014 он	2015 он	2014 он	2015 он	2014 он	2015 он
1	Гудамж талбайн гэрэлүүлэг	ш	1242	670	12	10	1369.6	965.8
2	Тохижилт, бичил цэцэрлэг	тоо	13	10	13	10	929.4	457.5
3	Явган зам, шат гүүр, зам сайжруулах	м <sup>2</sup>	6066	8980	34	19	599.4.	459.2
4	Ундны усны худаг, үер усны далан, ус зайлуулах хоолой, шуудуу	ш	5	4	5	4	170.0	110.0

	татах бохирын цооног хийх							
<b>5</b>	Байрны ус зайлуулах, фасад засвар	байр		7		7		304.0
<b>6</b>	Рашаан бүлгийн эх хамгаалах	ш		2		2		55,0
<b>7</b>	Хаягжуулалт	багц		5		5		100.0
<b>8</b>	Ажлын байр бий болгох, НААҮ-ний төсөл	ш		1		1		110.2
<b>Дүн</b>					64	58	3068.5	2551.8

2015 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын 37.8 хувийг гудамж талбайн гэрэлтүүлгийн ажил, 17.9 хувийг тохижилт, бичил цэцэрлэг байгуулах, 18.0 хувийг явган зам, шат гүүр, зам сайжруулах, 11.9 хувийг фасад дуулаалгын ажил, дээвэр засвар, 3.9 хувийг хагжуулалт, 4.3 хувийг үер усны далан, ус зайлуулах хоолой, шуудуу татах, бохирын цооног хийх, 6.1 хувийг рашаан бүлгийн эх хамгаалах, худаг гаргах, ажлын байр бий болгох ажилд тус тус зарцуулагдсан байна.


Зураг 3. ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хороогоор



Мөн 2015 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр барилга, байгууламж, дэд бүтэц, тохижилт, тавилга, техник, тоног төхөөрөмжийн чигэлэлээр нийт 3810.4 сая

төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн нь өнгөрсөн оноос 1172.0 сая төгрөгөөр буюу 44.4 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 4. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт



2015 оны 12-р сарын байдлаар 9428.6 мян.м/кв зам талбай цэвэрлэж, 104.9 мян.м/куб хог тээвэрлэсэн байна. Ажил үйлчилгээний орлого 5104.4 сая төгрөг болсон байна. Орлогын эх үүсвэрийг ангилвал 17.4 хувийг зам талбай, 37.6 хувийг гэр хорооллоос, 22.0 хувийг орон сууцнаас, 23.0 хувийг албан газраас тус тус олсон орлого эзэлж байна.

Хүснэгт 3. Тохижилтын ажил

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2014 он	2015 он	Зөрүү	%
Цэвэрлэсэн талбай		мян.мI	10503.6	9428.6	-1075.0	10.2
Тээвэрлэсэн хог		мян.мI	182.9	104.9	-78.0	42.6
Үүнээс:	Орон сууц	мян.мI	45.7	26.2	-19.5	42.7
	Гэр хороолол	мян.мI	82.3	47.2	-35.1	42.6
	Албан газар	мян.мI	27.4	15.7	-11.7	42.7
	Зам талбай	мян.мI	27.4	15.7	11.7	42.7
Ажил үйлчилгээний орлого		сая төгрөг	5712.2	5104.4	-607.8	10.6
Үүнээс:	Зам талбай	мян.төг	706.8	888.2	181.4	25.7
	Гэр хороолол	мян.төг	2888.5	1919.9	-968.6	33.5
	Орон сууц	мян.төг	1222.7	1124.8	-97.9	8.0
	Албан газар	мян.төг	894.2	1171.5	277.3	31.0


Дүүргийн хэмжээнд мод, бут сөөг зэрэг ногоон байгууламж байгуулахад 416.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь өнгөрсөн оноос 38.3 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна. Тохижилтын ажлын 43.1 хувийг шилмүүст мод тарихад, 3.7 хувийг бут сөөг тарихад, 5.2 хувийг амьд хашлага, 48.0 хувийг цэцэг, зүлгэнд зарцуулсан байна.

Хүснэгт 4. Тохижилтын ажил, оноор

№	Төрөл	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он
1	Мод	ш	1710	6906	1057	4487
2	Бут сөөг	ш	2150	7131	2500	5653
3	Амьд хашлага	ш	28833	49901	19745	31049
4	Цэцэг	м <sup>2</sup>	758	627	50	123

Хүн 18 мод тарихад амьдралынхаа туршид амьсгалсан агаараа эх дэлхийдээ буцааж өгч чаддаг бөгөөд бүх нийтээр мод тарих хөдөлгөөн өрнүүлсэн цагаас буюу 2013-2015 онуудад Чингэлтэй дүүрэг нийт 1011.2 мянган ширхэг мод бут тарьсан байна.

Зураг 3. Ногоон байгууламж, төрлөөр





СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ:

[WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

[WWW.UBSTAT.MN](http://WWW.UBSTAT.MN)

[WWW.CHINGELTEI.GOV.MN](http://WWW.CHINGELTEI.GOV.MN)